

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУГ-ын 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/008/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenhandd@audit.gov.mn Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.15 № 133

танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ УСАН СПОРТ
ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ГАЗАР
УТУГ-ЫН ЗАХИРАЛ Т.СҮХБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТУГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Гаднын тамирчдад байгууллагын төсвөөс 1,060.0 мянган төгрөгөөр бэлтгэлийн хувцас, ажилчдад 560.0 мянган төгрөгийн хувцас хийлгүүлэн зардлыг төлсөн,
- Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,199.0 мянган төгрөгийг илүү олгосон,
- Сар шинийн баярыг тохиолдуулж ажилчдад 3,900.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон,
- Түрээсийн орлогын 40.0 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн, тооцоо бодоогүй, хөрөнгө, бараа материал бодитоор бүрэн байгаа эсэх нь баримтаар нотлогдохгүй,
- Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 18,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Цогт сумд шилжүүлсэн байна.

822511000401

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.10, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 2, 30 дугаар зүйлийн 30.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, ерийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2023 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх, түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнийг тогтоох журмыг шинэчлэн батлах тухай" журамтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага 5 иргэн, аж ахуй нэгжтэй түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлого олсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөгөөр нийт орлогыг 725,973.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 725,973.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 85.1 хувийг санхүүжихээр баталсан байна.

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс 626,216.9 мянган төгрөг авч, үйл ажиллагааны орлогоос 142,537.0 мянган төгрөг олж, 865,398.6 мянган төгрөгийн зардал гаргаж, 96,644.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 зорилт, 29 арга хэмжээний хэрэгжилтийг 93.0 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Аудитлагдсан Үлдэгдэл	
		2025 оны 1-р сарын 01	2025 оны 12-р сарын 01
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	714,290.64	3,125,945.81
1.1.2	Дансны авлага	-	13,643.05
1.1.6	Бараа материал	27,779,180.00	26,729,080.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	28,493,470.64	29,868,668.86
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,134,526,352.51	4,015,004,294.24
1.2.2	Биет бус хөрөнгө	108,820,568.29	110,832,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,243,346,920.80	4,125,836,794.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,271,840,391.44	4,155,705,463.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	59,175,968.80	40,118,609.40
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	59,175,968.80	40,118,609.40
2.1.1.1	Дансны өглөг	59,175,968.80	40,118,609.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	59,175,968.80	40,118,609.40
2.2	Өр төлбөрийн нийт дүн	59,175,968.80	40,118,609.40
2.3.1	Өмч: - төрийн	4,199,545,086.84	4,199,545,086.84
2.3.9	Хуримтлагдсан ашиг	13,119,335.80	(83,958,233.14)
2.3.10	Өмнөх үеийн үр дүн	(87,721,411.05)	13,119,335.80
	Тайлант үеийн үр дүн	100,840,746.85	(97,077,568.94)
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,212,664,422.64	4,115,586,853.70
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,271,840,391.44	4,155,705,463.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 1-р сарын 1	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	115,634,371.90	117,046,809.00
2	Борлуулалтын өртөг	3,065,313.00	-
3	Нийт ашиг (алдагдал)	112,569,058.90	117,046,809.00
4	Түрээсийн орлого	6,667,900.00	10,520,600.00
8	Бусад орлого	773,514,297.00	764,674,371.84
9	Борлуулалт, маркетингийн зардал	337,808,213.04	844,094,731.97
10	Ерөнхий ба удирдлагын зардал	452,174,838.01	143,509,417.81
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,927,458.00	1,715,200.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	100,840,746.85	(97,077,568.94)
19	Орлогын татварын зардал		-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	100,840,746.85	(97,077,568.94)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	100,840,746.85	(97,077,568.94)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 1-р сарын 01	2025 оны 12-р сарын 01
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	630,920,771.90	757,023,350.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	116,074,371.90	128,920,742.00
	Буцаан авсан албан татвар		861,008.00
	Татаас, санхүүжилтийн орлого	507,476,200.00	602,216,900.00
	Бусад мөнгөн орлого	7,370,200.00	25,024,700.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	631,401,705.21	754,611,694.83
	Ажиллагчдад төлсөн	257,133,588.00	311,021,631.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,233,719.53	90,916,741.13
	Бараа материал худалдан авахад төлсөн	69,013,386.00	76,110,950.00
	Ашиглалтын зардалд төлсөн	157,997,640.78	202,383,158.53
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	220,000.00	980,000.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	24,196,733.00	40,443,139.17
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	47,606,637.90	32,756,075.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(480,933.31)	2,411,655.17
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(480,933.31)	2,411,655.17
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,195,223.95	714,290.64
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	714,290.64	3,125,945.81

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 31-ний үлдэгдэл	4,199,545,086.84	(87,721,411.05)	4,111,823,675.79
3	Залруулсан үлдэгдэл	4,199,545,086.84	(87,721,411.05)	4,111,823,675.79
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		100,840,746.85	100,840,746.85
9	2024 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	4,199,545,086.84	13,119,335.80	4,212,664,422.64
11	Залруулсан үлдэгдэл	4,199,545,086.84	13,119,335.80	4,212,664,422.64
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(97,077,568.94)	(97,077,568.94)
17	2025 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	4,199,545,086.84	(83,958,233.14)	4,115,586,853.70

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант оны		Хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	96,000,000.00	117,046,809.00	(21,046,809.00)	121.9

	Бусад мөнгөн орлого	12,124,200.00	172,978,071.84	(160,853,871.84)	1426.7
	Татаас, санхүүжилтын орлого	617,848,972.00	602,216,900.00	15,632,072.00	97.5
	ОРЛОГО	725,973,172.00	892,241,780.84	(348,169,289.68)	122.9
	1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	
	1.3 Нийт ашиг	725,973,172.00	892,241,780.84	(348,169,289.68)	122.9
	Үйл ажиллагааны зардал	700,172,972.00	844,094,731.97	(143,921,759.97)	120.6
	Бусад зардал	25,800,000.00	145,224,617.81	(119,424,617.81)	562.9
	1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	725,972,972.00	989,319,349.78	(263,346,377.78)	0.0
	1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	-	(97,077,568.94)	97,077,568.94	0.0
	3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-	(97,077,568.94)	97,077,568.94	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар 3,592.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 3,592.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар залруулагдаагүй нийт 478,595.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 478,595.1 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрч зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 2 төлбөрийн акт, 3 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

1. Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,199.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Гадны тамирчдад байгууллагын төсвөөс 1,060.0 мянган төгрөгөөр бэлтгэлийн цамц, өмд хийлгэсэн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гадны тамирчдад хийлгэж өгсөн хувцасны мөнгийг төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүл төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, тооллого чанаргүй, хөрөнгө, бараа материал бодитоор бүрэн байгаа эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Жилийн эцсийн тооллогын баримтаар 18,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад Цогт сум руу шилжүүлсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", 77 дугаар зүйлийн 77.3-т "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Ажилчдад хувцас хийлгүүлсэн 560.0 мянган төгрөгийн зардлыг байгууллагаас төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйдийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

Илрүүлэлт: Сар шинийн баярыг тохиолдуулж ажилчдад 3,900.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Хоёр. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд 3 хуулийн этгээдтэй холбоотой он дамнасан 459.3 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд бүртгэлтэй өр төлбөрийн эзэн холбогдогчийг тодруулж, тооцоо нийлэх, өр төлбөрийг барагдуулах.

Гурав. Орлогын бүрдүүлэлттэй холбоотой

Илрүүлэлт: Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх журмыг зөрчин Жаргал асаа ХХК-тай Кафе, кофе шопын үйл ажиллагааны зориулалтаар хамтран ажиллах гэрээ байгуулж байгууллагын дансанд 500.0 мянган төгрөгийн түрээс хүлээн авч, орон нутгийн өмч хувьчлалын дансанд түрээсийн орлогын 40.0 хувийг байршуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 56 дугаар тогтоол "Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх, түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнийг тогтоох журмыг шинэчлэн батлах тухай"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчийн хөрөнгийг холбогдох журмын дагуу бусдад ашиглуулж, загвар гэрээний дагуу гэрээг байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруула агүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 3,592.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	3,592.8	-	-	1	3,592.8	1	3,592.8	-	-	-	-
Дүн		1	3,592.8	-	-	1	3,592.8	1	3,592.8	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	Гадны тамирчдад байгууллагын төсвөөс 1,060.0 мянган төгрөгөөр бэлтгэлийн цамц, өмд хийлгэсэн.	1	1,060.0	1	1,060.0	-	-			-	-	
	Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,199.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1	1,199.0	1	1,199.0	-	-			-	-	
	Ажилчдад хувцас хийлгүүлсэн 560.0 мянган төгрөгийн зардлыг байгууллагаас төлсөн.	1	560.0	-	-	1	560.0			-	-	
	Сар шинийн баярыг тохиолдуулж ажилчдад 3,900.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.	1	3,900.0	--	-	-	-		1	3,900.0	-	-
	Санхүүгийн тайланд 3 хуулийн этгээдтэй холбоотой он дамнасан 459.3 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.	1	459.3	-	-	-	-		1	459.3	-	-
	Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх журмыг зөрчин Жаргал асаа ХХК-тай Кафе, кофе шопын үйл ажиллагааны зориулалтаар хамтран ажиллах гэрээ байгуулж байгууллагын дансанд 500.0 мянган төгрөгийн түрээс хүлээн авч, орон нутгийн өмч хувьчлалын дансанд түрээсийн орлогын 40.0 хувийг байршуулаагүй.	1	500.0	-	-	-	-		1	500.0	-	-

	Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, тооллого чанаргүй, хөрөнгө, бараа материал бодитоор бүрэн байгаа эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.	1	452,616.8	-	-	1	452,616.8	-	-	-	-
	Жилийн эцсийн тооллогын баримтаар 18,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад Цогт сум руу шилжүүлсэн байна.	1	18,300.0	-	-	1	18,300.0	-	-	-	-
Нийт		8	478,595.1	2	2,259.0	3	471,476.8	3	4,859.3	-	-